



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ  
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
 ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/302

Алтай хот

**Орон нутгийн судлах музейн барилга  
 байгууламжийг ашиглалтад оруулах  
 комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн БСШУСЯ/201902287 дугаар гэрээт Орон нутгийн судлах музейн барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Комиссын дарга: Л.Хаш-Эрдэнэ (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- Гишүүдэд:
- Б.Ган-Эрдэнэ (Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын хяналтын инженер)
  - Ц.Идэр (Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын хяналтын инженер)
  - С.Мөнхжаргал (Нийгмийн бодлогын бодлогын хэлтсийн дарга)
  - М.Мандаххүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
  - Ж.Мөнхчимэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
  - С.Цагаанбаатар (Соёл, урлагийн газрын дарга)
  - Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер)

2.

Н.Долгорсүрэн	("Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн ахлах инженер)
Э.Пүрэвжаргал	("Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер)
Ц.Амарсанаа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
Ц.Оюунзул	(Орон нутгийн судлах музейн захирал) (ашиглагч)
Г.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)
Б.Бээжин	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)
Д.Цэвэлмаа	("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер)
Г.Хүрэлхүү	("Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)
Г.Цэлмэгтуяа	("Солонго дулааны станц" ААТҮГ-ын ерөнхий инженер)
Б.Оюунболд	("Ди Ди Эй Жи" ХХК-ийн инженер) (зохиогч)
Б.Ганхөлөг	("Жи Ти Кэй Эс" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга: Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)

2. Барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулахдаа барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн шалгаж, түүний холбогдох баримт бичгийн бүрдлийг хянан баталгаажуулж, үр дүнг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчийн хөрөнгөд бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Соёлын урлагийн газар (С.Цагаанбаатар), Орон нутгийн судлах музей (Ц.Оюунзул)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ